



**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН
ХОРШООДЫН
2021 ОНЫ ХОЁРДУГААР
УЛИРЛЫН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН
ТАНИЛЦУУЛГА**

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ГАЗАР

УЛААНБААТАР ХОТ

АГУУЛГА

НЭГ.САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	2
1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл.....	2
1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл.....	3
1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл.....	4
1.4 Бодлого, зохицуулалтын орчин.....	5
ХОЁР.НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД	6
2.1 Статистик үзүүлэлтүүд.....	6
2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд.....	8
2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд.....	9
2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд.....	9
ГУРАВ.НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	10
3.1 Хөрөнгийн бүтцийн талаар.....	10
3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар.....	11
3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар.....	12
3.4 Зээлийн чанарын талаар.....	13
ДӨРӨВ.НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	14
4.1 Эх үүсвэрийн бүтцийн талаар.....	14
4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар.....	15
4.3 Бусдаас авсан зээл, өр төлбөрийн талаар.....	15
4.4 Бусад богино хугацаат өр төлбөрийн талаар.....	16
4.5 Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн талаар.....	16
4.6 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар.....	17
ТАВ.ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГАА	17
5.1 ХЗХ-дын орлогын талаар.....	17
5.2 ХЗХ-дын зардлын талаар.....	18
5.3 ХЗХ-дын ашигт ажиллагааны талаар.....	18
ЗУРГАА.ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	19
6.1 ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар.....	19
ДОЛОО.ДҮГНЭЛТ	20

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2021 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2021.08.23


Улаанбаатар хот

НЭГ. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл

2021 оны 2 дугаар улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон 234 хадгаламж, зээлийн хоршоо (цаашид “ХЗХ” гэх) үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 22 ХЗХ буюу 8.6 хувиар буурсан үзүүлэлт юм. Тайлант улиралд нийт ХЗХ-дын 41.9 хувь буюу 98 ХЗХ орон нутагт, 58.1 хувь буюу 136 ХЗХ Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулсан байна.

График 1: ХЗХ-дын тоо /хот, орон нутгаар/




Тайлант улиралд Хорооны хуралдаанаар 32 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 5 ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, 15 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэсэн байна. Мөн 2021 оны 2 дугаар улиралд 1 ХЗХ-нд санхүүгийн түрээсийн болон мөнгөн гуйвуулгын үйл ажиллагаа эрхлэх, 2 ХЗХ-нд 3 салбар нээх

зөвшөөрлийг тус тус олгож, 24 ХЗХ-ны сонгуульт гишүүд, 6 ХЗХ-ны ажлын байрны хаягийн өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэсэн байна.

Хүснэгт 1: ХЗХ-дын тусгай зөвшөөрлийн мэдээлэл

Он	2017	2018	2019	2020	2021.ИИ
ХЗХ-дын тоо	290	279	261	249	234
Шинээр олгосон	17 /1/	18	17	14	-
Хүчингүй болгосон	8	29	35	26	15
Түдгэлзүүлсэн	21	19	10	23	5
Сэргээсэн	4	7	1	6	-
ТЗ-ийн хугацаа сунгасан	54	100	52	49	71

Зураг 1: ХЗХ-дын эрхэлж буй үйл ажиллагаа



1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл

2021 оны 2 дугаар улирлын байдлаар 234 ХЗХ 64 салбар, 793 ажилтан, 73,719 гишүүн /73,536 иргэн, 183 хуулийн этгээд/-тэйгээр Монгол Улсын 21 аймаг, 9 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байна.

Улаанбаатар хотын 9 дүүрэгт 136 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19 ХЗХ буюу 12.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүргүүдэд хамгийн их төвлөрөлтэй байна.

Орон нутагт Сэлэнгэ аймгаас бусад 20 аймагт 98 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 ХЗХ буюу 3.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Баян-Өлгий, Увс, Говь-Алтай, Ховд аймгуудад ХЗХ-д ихээр төвлөрсөн байгаа бол Говьсүмбэр, Өвөрхангай, Сүхбаатар аймгуудад тус бүр 1 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 3: ХЗХ-дын тархалт



Зураг 2: Улаанбаатар хотын ХЗХ-дын тархалт




График 2: “Гялс төгрөг” ХЗХ-ны салбарын тархалт



Тайлант улирлын байдлаар нийт 9 ХЗХ 64 салбартайгаар үйл ажиллагаа эрхэлж байна. Салбарын тоо өмнөх оны мөн үеэс 12 салбар буюу 23.1 хувиар нэмэгдсэн байна.

Салбарын тархалтын хувьд 4 ХЗХ-ны 7 салбар Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж, 5 ХЗХ-ны 57 салбар орон нутагт үйл ажиллагаа явуулж байна. Үүнд “Гялс төгрөг” ХЗХ-ны 52 салбар Төв, Баян-Өлгий аймгаас бусад 19 аймагт тархалттай байна.

1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл


2021 оны 2 дугаар улирлын байдлаар ХЗХ-дын нийт гишүүдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,489 гишүүн буюу 2.1 хувиар нэмэгдэж 73,719-д хүрсэн үзүүлэлттэй байна. Нийт гишүүдийн 0.2 хувь буюу 183 хуулийн этгээд, 50.6 хувь буюу 37,330 эмэгтэй гишүүн байна.

Зураг 4: ХЗХ-ны гишүүдийн мэдээлэл



Нийт гишүүдийн 58.8 хувь буюу 43,322 гишүүн Улаанбаатар хотод бүртгэлтэй бол 41.2 хувь буюу 30,397 гишүүн орон нутагт бүртгэлтэй байна.


График 3: ХЗХ-дын тоо болон гишүүдийн өөрчлөлт /хот, орон нутгаар/



2018-2021 онуудад ХЗХ-дын тоо буурсан ч гишүүдийн тоо тогтмол өссөөр байна.

Нийт 234 ХЗХ-ны 44.0 хувь буюу 103 ХЗХ 20-100 гишүүнтэй, 44.0 хувь буюу 103 ХЗХ 101-500 гишүүнтэй, 8.1 хувь буюу 19 ХЗХ 501-1,000 гишүүнтэй, 3.8 хувь буюу 9 ХЗХ 1,001-ээс дээш гишүүнтэй байна.

График 4: ХЗХ-ны гишүүдийн төвлөрөл



- 20-100 гишүүнтэй
- 101-500 гишүүнтэй
- 501-1,000 гишүүнтэй
- 1,001-ээс дээш гишүүнтэй

Гишүүдийн төвлөрлийг хүснэгтээр харуулбал 1,001-ээс дээш гишүүнтэй 9 ХЗХ-ны гишүүд нийт гишүүдийн 46.5 хувийг эзэлж байна.

Хүснэгт 2: ХЗХ-ны гишүүнчлэл, интервалаар

Гишүүд /интервалаар/	ХЗХ-ны тоо	Гишүүд	Эзлэх хувь
20-100 гишүүнтэй	103	5,988	8.1%
101-500 гишүүнтэй	103	20,645	28.0%
501-1,000 гишүүнтэй	19	12,813	17.4%
1,001-ээс дээш гишүүнтэй	9	34,273	46.5%
Нийт	234	73,719	100.0%

1.4 Хууль тогтоомжийн өөрчлөлт

- УИХ-ын ЭЗБХ-ны 2020.10.27-ны өдрийн 02 дугаар тогтоолоор байгуулсан Хоршооны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан бөгөөд хуулийг УИХ-аас 2021.05.06-ны өдөр баталсан. Хоршооны тухай хууль батлагдсан тул Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн төслийг эрх бүхий байгууллагад өргөн мэдүүлэхээр бэлтгэж байна.
- Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүрээнд Хорооны дарга, Сангийн сайдын 2015 оны 145/124 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “ХЗХ-ны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын зээлийн ангилалд Хорооны 2021 оны 266 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж 2021.07.01-2021.12.31-ний хугацаанд мөрдүүлэхээр тогтсон.
- Цахим шилжилтэд учирч буй хүндрэлийг хэрхэн даван туулах талаар ХЗХ-дын төлөөлөлтэй 2021 оны 5 дугаар сарын 28, 6 дугаар сарын 04-ний өдрүүдэд 3 удаагийн хэлэлцүүлэг, ХЗХ-дын зээлдэгчийн мэдээллийг Хорооны дэд систем үүсгэн дамжуулах талаар Монголбанкны Зээлийн мэдээллийн албатай 2021 оны 6 дугаар сарын 04-ний өдөр, дундын мэдээллийн сан үүсгэх талаар 2021 оны 6 дугаар сарын 14-ний өдөр УБЕГ-ын ХЭУБГ-тай тус тус уулзалт зохион байгуулсан.
- ХЗХ-дын гишүүдийн бүртгэлийг цахимжуулсан бөгөөд Зөвшөөрлийн цахим системд 2021.06.30-ны өдрийн байдлаар 222 ХЗХ-ны 64,181 гишүүдийн мэдээлэл бүрэн орсон байна.

Хүснэгт 4: ХЗХ-дын зээлдэгчдийн статистик үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ	ХЗХ-дын нийт зээлдэгч		ҮҮНЭЭС:			
			Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
ХЗХ-дын тоо	234	100.0%	136	58.1%	98	41.9%
Нийт зээлийн үлдэгдэл	186,814,868.28	100.0%	152,332,002.71	81.5%	34,482,865.57	18.5%
Нийт зээлдэгчийн тоо	32,534	100.0%	18,663	57.4%	13,871	42.6%
Иргэн	32,463	99.8%	18,607	99.7%	13,856	99.9%
Эмэгтэй	19,255	59.2%	11,612	62.2%	7,643	55.1%
Хуулийн этгээд	71	0.2%	56	0.3%	15	0.1%
Зээлдэгчдийн насжилт	32,463	100.0%	18,607	57.3%	13,856	42.7%
18-35 насны	12,789	39.4%	9,396	50.5%	3,393	24.5%
36-45 насны	7,649	23.5%	3,591	19.3%	4,058	29.3%
46-55 насны	8,205	25.3%	4,255	22.9%	3,950	28.5%
55-аас дээш	3,820	11.8%	1,365	7.3%	2,455	17.7%
Зээлдэгчдийн боловсрол	32,463	100.0%	18,607	57.3%	13,856	42.7%
Дээд	12,081	37.2%	7,698	41.4%	4,383	31.6%
Тусгай дунд	5,694	17.5%	3,404	18.3%	2,290	16.5%
Бүрэн дунд	10,669	32.9%	5,975	32.1%	4,694	33.9%
Дунд	3,310	10.2%	1,433	7.7%	1,877	13.6%
Бага	709	2.2%	97	0.5%	612	4.4%

Тайлант улиралд ХЗХ-д 32,534 зээлдэгчийн 186,814,868.28 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Нийт зээлдэгчийн 57.4 хувь буюу 18,663 зээлдэгч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт зээлийн 81.5 хувь буюу 152,332,002.71 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 42.6 хувь буюу 13,871 зээлдэгч орон нутгийн ХЗХ-

дын гишүүд ба нийт зээлийн 18.5 хувь буюу 34,482,865.57 мянган төгрөгийг бүрдүүлж байна.

Нийт зээлдэгчийн 99.8 хувь буюу 32,463 нь хувь хүн /үүний 59.2 хувь буюу 19,255 нь эмэгтэй/, 0.2 хувь буюу 71 нь хуулийн этгээд байна.

Хүснэгт 5: ХЗХ-дын хадгаламж эзэмшигчдийн статистик үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ	ХЗХ-дын нийт хадгаламж эзэмшигч		ҮҮНЭЭС:			
			Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
ХЗХ-дын тоо	234	100.0%	136	58.1%	98	41.9%
Нийт хадгаламжийн үлдэгдэл	191,164,216.50	100.0%	159,917,334.25	83.7%	31,246,882.25	16.3%
Нийт хадгаламж эзэмшигчийн тоо	35,122	100.0%	18,533	52.8%	16,589	47.2%
Эмэгтэй	18,340	52.2%	9,400	50.7%	8,940	53.9%
Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл	4,325,631	2.3%	3,652,016	2.3%	673,614	2.2%
Хугацаагүй хадгаламж эзэмшигчийн тоо	4,503	12.8%	3,570	19.3%	933	5.6%
Иргэн	4,485	12.7%	3,554	19.2%	931	5.6%
Хуулийн этгээд	18	0.1%	16	0.1%	2	0.0%
Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл	186,838,586	97.7%	156,265,318	97.7%	30,573,268	97.8%
Хугацаатай хадгаламж эзэмшигчийн тоо	30,619	87.2%	14,963	80.7%	15,656	94.4%
Иргэн	30,571	87.0%	14,951	80.7%	15,620	94.2%
Хуулийн этгээд	48	0.1%	12	0.1%	36	0.2%
Хадгаламж эзэмшигчдийн насжилт	35,056	100.0%	18,505	52.8%	16,551	47.2%
18-35 насны	10,714	30.6%	6,206	33.5%	4,508	27.2%
36-45 насны	10,348	29.5%	5,486	29.6%	4,862	29.4%
46-55 насны	8,208	23.4%	4,232	22.9%	3,976	24.0%
55-аас дээш	5,786	16.5%	2,581	14.0%	3,205	19.4%

Хадгаламж эзэмшигчдийн боловсрол	35,056	100.0%	18,505	52.8%	16,551	47.2%
Дээд	16,126	46.0%	10,991	59.4%	5,135	31.0%
Тусгай дунд	5,586	15.9%	3,227	17.4%	2,359	14.3%
Бүрэн дунд	8,306	23.7%	3,380	18.3%	4,926	29.8%
Дунд	3,463	9.9%	694	3.7%	2,769	16.7%
Бага	1,575	4.5%	213	1.2%	1,362	8.2%

2021 оны 2 дугаар улирлын байдлаар ХЗХ-д 35,122 хадгаламж эзэмшигчийн 191,164,216.50 мянган төгрөгийн хадгаламжийг татан төвлөрүүлсэн байна. Нийт хадгаламж эзэмшигчийн 52.8 хувь буюу 18,533 хадгаламж эзэмшигч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 83.7 хувь буюу 159,917,334.25 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 47.2 хувь буюу 16,589 хадгаламж эзэмшигч нь орон нутгийн ХЗХ-

дын гишүүд ба нийт хадгаламжийн 16.3 хувь буюу 31,246,882.25 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Нийт хадгаламж эзэмшигчийн 12.8 хувийг хугацаагүй хадгаламжтай, 87.2 хувийг хугацаатай хадгаламжтай гишүүд эзэлж байна.

Нийт хадгаламж эзэмшигчийн 99.9 хувь буюу 35,056 нь хувь хүн /үүний 52.2 хувь буюу 18,340 нь эмэгтэй/, 0.1 хувь буюу 66 нь хуулийн этгээд байна.

2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд

2021 оны 2 дугаар улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 270,475,472.20 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.4 хувь буюу 36,035,701.72 мянган төгрөгөөр өсөж банкны зах зээлийн 0.7 хувьтай тэнцэж байна.

Тайлант улиралд нийт зээлийн үлдэгдэл 13.2 хувь буюу 21,747,928.67 мянган

төгрөг, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 17.0 хувь буюу 27,770,132.47 мянган төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт орлого 4.2 хувь буюу 1,132,903.94 мянган төгрөг, нийт зарлага 5.3 хувь буюу 1,150,393.60 мянган төгрөгөөр тус тус өссөнөөр нийт цэвэр орлого 0.3 хувь буюу 17,489.67 мянган төгрөгөөр буурч 5,171,375.79 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 6: ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2020 оны II улирал	2021 оны II улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
Нийт хөрөнгө	234,439,770.49	270,475,472.20	36,035,701.72	15.4%
Банкны зах зээлд эзлэх хувь	0.7%	0.7%		
Нийт зээл	165,066,939.62	186,814,868.28	21,747,928.67	13.2%
Банкны зах зээлд эзлэх хувь	0.9%	1.0%		
Нийт чанаргүй зээл	7,112,887.04	6,923,746.89	-189,140.15	-2.7%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	4.3%	3.7%	-0.6%	-14.0%
Банкны зах зээлд эзлэх хувь	0.4%	0.4%	0.0%	-10.9%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	163,394,084.04	191,164,216.50	27,770,132.47	17.0%
Банкны зах зээлд эзлэх хувь	1.1%	1.0%		
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	18,225,406.96	22,593,048.55	4,367,641.59	24.0%
Нийт хоршоологчдын өмч	27,149,772.37	33,023,401.87	5,873,629.50	21.6%
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	9,671,651.81	6,615,725.14	-3,055,926.67	-31.6%
Нийт орлого	26,742,618.59	27,875,522.52	1,132,903.94	4.2%
Нийт зарлага	21,553,753.13	22,704,146.73	1,150,393.60	5.3%
Цэвэр орлого, алдагдал	5,188,865.46	5,171,375.79	-17,489.67	-0.3%

2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 136 ХЗХ-ны нийт хөрөнгө 224,641,124.16 мянган төгрөг нь зах зээлийн 83.1 хувь, нийт зээл 152,332,002.71 мянган төгрөг нь зах зээлийн 81.5 хувь, нийт хадгаламж 159,917,334.25 мянган төгрөг нь зах зээлийн 89.0 хувийг тус тус бүрдүүлж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.6 хувь буюу 298,720.73 мянган төгрөгөөр буурч 6,165,393.08 мянган төгрөгт хүрсэн нь нийт зээлийн 4.0 хувийг бүрдүүлж байна. Банк, ББСБ, төсөл

хөтөлбөрөөс авсан зээл өмнөх оны мөн үеэс 31.3 хувь буюу 6,525,947.96 мянган төгрөгөөр буурсан байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 0.7 хувь буюу 157,642.28 мянган төгрөгөөр, нийт зарлага 0.9 хувь буюу 162,962.62 мянган төгрөгөөр тус тус өссөнөөр нийт цэвэр орлого 0.1 хувь буюу 5,320.34 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Улаанбаатар хотын 78 ХЗХ “Монголбанкны зээлийн мэдээллийн санд мэдээлэл өгөх, авах гэрээ”-г байгуулсан байна.

Хүснэгт 7: Улаанбаатар хотын ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2020 оны II улирал	2021 оны II улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
Нийт хөрөнгө	200,671,345.31	224,641,124.16	23,969,778.85	11.9%
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	85.6%	83.1%	-2.5%	-3.0%
Нийт зээл	138,458,943.73	152,332,002.71	13,873,058.98	10.0%
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	83.9%	81.5%	-2.3%	-2.8%
Нийт чанаргүй зээл	6,464,113.81	6,165,393.08	-298,720.73	-4.6%
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	90.9%	89.0%	-1.8%	-2.0%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	4.7%	4.0%	-0.6%	-13.3%
Нийт таган төвлөрүүлсэн хадгаламж	141,908,194.29	159,917,334.25	18,009,139.96	12.7%
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	86.9%	83.7%	-3.2%	-3.7%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	13,223,725.48	16,507,679.66	3,283,954.17	24.8%
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	72.6%	73.1%	0.5%	0.7%
Нийт хоршоологчдын өмч	22,007,357.34	27,013,092.56	5,005,735.22	22.7%
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	81.1%	81.8%	0.7%	0.9%
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	9,498,026.64	6,525,947.96	-2,972,078.69	-31.3%
Нийт орлого	22,036,187.61	22,193,829.89	157,642.28	0.7%
Нийт зарлага	17,920,822.91	18,083,785.52	162,962.62	0.9%
Цэвэр орлого, алдагдал	4,115,364.71	4,110,044.37	-5,320.34	-0.1%

2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 98 ХЗХ-ны нийт хөрөнгө 45,834,348.05 мянган төгрөг нь зах зээлийн 16.9 хувь, нийт зээлийн үлдэгдэл 34,482,865.57 мянган төгрөг нь зах зээлийн 18.5 хувь, нийт хадгаламж 31,246,882.25 мянган төгрөг нь зах зээлийн 16.3 хувийг тус тус эзэлж байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 20.7 хувь буюу 975,261.66 мянган төгрөг, нийт

зарлага 27.2 хувь буюу 987,430.99 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, цэвэр орлого 1.1 хувь буюу 12,169.33 мянган төгрөгөөр буурч 1,061,331.42 мянган төгрөгт хүрсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу орон нутгийн 31 ХЗХ “Монголбанкны зээлийн мэдээллийн санд мэдээлэл өгөх, авах гэрээ”-г байгуулсан байна.

Хүснэгт 8: Орон нутгийн ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2020 оны II улирал	2021 оны II улирал	Өөрчлөлт	
			Дүн	хувь
Нийт хөрөнгө	33,768,425.18	45,834,348.05	12,065,922.87	35.7%
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	14.4%	16.9%	2.5%	17.6%

Нийт зээл	26,607,995.88	34,482,865.57	7,874,869.69	29.6%
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	16.1%	18.5%	2.3%	14.5%
Нийт чанаргүй зээл	648,773.23	758,353.81	109,580.58	16.9%
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	9.1%	11.0%	1.8%	20.1%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	2.4%	0.5%	-1.9%	-79.6%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	21,485,889.75	31,246,882.25	9,760,992.50	45.4%
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	13.1%	16.3%	3.2%	24.3%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	5,001,681.48	6,085,368.90	1,083,687.42	21.7%
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	27.4%	26.9%	-0.5%	-1.9%
Нийт хоршоологчдын өмч	5,142,415.03	6,010,309.31	867,894.28	16.9%
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	18.9%	18.2%	-0.7%	-3.9%
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	173,625.17	89,777.18	-83,847.99	-48.3%
Нийт орлого	4,706,430.97	5,681,692.63	975,261.66	20.7%
Нийт зарлага	3,632,930.22	4,620,361.21	987,430.99	27.2%
Цэвэр орлого, алдагдал	1,073,500.75	1,061,331.42	-12,169.33	-1.1%

ГУРАВ. НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

3.1 Хөрөнгийн бүтцийн талаар

Хүснэгт 9: ХЗХ-дын хөрөнгийн бүтэц /мянган төгрөгөөр/

ХӨРӨНГӨ	2020 оны II улирал		2021 оны II улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлтийн хөрөнгө	230,241,669.49	98.2%	262,164,699.33	96.9%	31,923,029.83	13.9%
Мөнгөн хөрөнгө	59,495,025.49	25.4%	69,431,704.31	25.7%	9,936,678.82	16.7%
Бэлэн мөнгө	5,035,705.79	2.1%	4,262,483.59	1.6%	-773,222.20	-15.4%
Банкинд байршуулсан харилцах	43,909,740.46	18.7%	18,220,772.64	6.7%	-25,688,967.82	-58.5%
Банкинд байршуулсан хадгаламж	10,549,579.23	4.5%	46,948,448.07	17.4%	36,398,868.84	345.0%
Богино хугацаат хөрөнгө оруулалт	100,000.00	0.0%	150,000.00	0.1%	50,000.00	50.0%
Арилжааны үнэт цаас	100,000.00	0.0%	150,000.00	0.1%	50,000.00	50.0%
Зээл /цэврээр/	160,128,071.91	68.3%	181,775,548.93	67.2%	21,647,477.02	13.5%
Нийт зээл	165,066,939.62	70.4%	186,814,868.28	69.1%	21,747,928.67	13.2%
Хэвийн зээл	152,815,447.67	65.2%	174,783,271.82	64.6%	21,967,824.15	14.4%
Хугацаа хэтэрсэн зээл	5,138,604.91	2.2%	5,107,849.57	1.9%	-30,755.34	-0.6%
Чанаргүй зээл	7,112,887.04	3.0%	6,923,746.89	2.6%	-189,140.15	-2.7%
(Зээлийн эрсдэлийн сан)	4,938,867.71	2.1%	5,039,319.35	1.9%	100,451.64	2.0%
Авлага	8,085,075.63	3.4%	9,087,523.25	3.4%	1,002,447.63	12.4%
Байгууллага, хүмүүсээс авах авлага	1,409,119.27	0.6%	875,761.64	0.3%	-533,357.64	-37.9%
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	6,675,956.35	2.8%	8,211,761.62	3.0%	1,535,805.26	23.0%
Бусад эргэлтийн хөрөнгө	1,088,120.43	0.5%	999,815.38	0.4%	-88,305.05	-8.1%
Өмчлөх бусад хөрөнгө /цэвр/	1,345,376.04	0.6%	720,107.46	0.3%	-625,268.58	-46.5%
Өмчлөх бусад хөрөнгө	1,387,160.84	0.6%	726,185.81	0.3%	-660,975.04	-47.6%
(Өмчлөх бусад хөрөнгийн хасагдуулга)	41,784.80	0.0%	6,078.35	0.0%	-35,706.46	-85.5%
Эргэлтийн бус хөрөнгө	4,198,100.99	1.8%	8,310,772.88	3.1%	4,112,671.88	98.0%
Үндсэн хөрөнгө /цэвр/	3,954,080.80	1.7%	4,175,154.12	1.5%	221,073.32	5.6%
Үндсэн хөрөнгө	5,422,421.96	2.3%	6,062,336.30	2.2%	639,914.34	11.8%
(Хуримтлагдсан элэгдэл)	1,468,341.16	0.6%	1,887,182.18	0.7%	418,841.02	28.5%
Биет бус хөрөнгө	228,400.19	0.1%	4,120,132.63	1.5%	3,891,732.43	1703.9%
Биет бус хөрөнгө	298,940.44	0.1%	4,179,559.93	1.5%	3,880,619.48	1298.1%
(Биет бус хөрөнгийн элэгдэл)	70,540.25	0.0%	59,427.30	0.0%	-11,112.95	-15.8%
Хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө	15,620.00	0.0%	15,486.13	0.0%	-133.87	-0.9%
Хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө	15,620.00	0.0%	15,486.13	0.0%	-133.87	-0.9%
Хөрөнгийн дүн	234,439,770.49	100.0%	270,475,472.20	100.0%	36,035,701.72	15.4%

Зураг 5: Хөрөнгийн зарим үзүүлэлтээс /мянган төгрөгөөр/



Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 13.2 хувь буюу 21,747,928.67 мянган төгрөгөөр өсөж 186,814,868.28 мянган төгрөгт хүрсэн бөгөөд 5,039,319.35 мянган төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 181,775,548.93 мянган төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй байна. Харин хугацаа хэтэрсэн зээлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад (0.6) хувь буюу 30,755.34 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.


ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгийн өөрчлөлтийг сүүлийн 5 жилээр харьцуулахад 2018-2021 онуудад ХЗХ-дын тоо буурсан ч хөрөнгийн хэмжээ тасралтгүй өссөн үзүүлэлттэй байна.

3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар

ХЗХ-дыг хөрөнгийн хэмжээгээр нь ангилахад 10 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 4 ХЗХ-ны нийт хөрөнгө 173,201,375.57 мянган төгрөг нь зах зээлийн нийт хөрөнгийн 64.0 хувийг, гишүүдийн тоо 22,707 байгаа нь нийт гишүүдийн 30.8 хувийг тус тус эзэлж байна.


Хүснэгт 10: ХЗХ-дын хөрөнгийн төвлөрөл, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Нийт хөрөнгө			
			Дүн	Хувь	Тоо	Хувь
1	10,000,000.0-аас дээш	4	173,201,375.57	64.0%	22,707	30.8%
2	1,000,000.0 - 10,000,000.0	19	59,150,970.46	21.9%	19,646	26.6%
3	500,000.0-1,000,000.0	18	13,445,780.97	5.0%	7,073	9.6%
4	100,000.0-500,000.0	78	17,891,891.38	6.6%	15,207	20.6%
5	50,000.0-100,000.0	72	5,575,992.18	2.1%	6,534	8.9%
6	10,000.0-50,000.0	38	1,186,176.18	0.4%	2,435	3.3%
7	10,000.0 хүртэл	5	23,285.47	0.01%	117	0.2%
Нийт дүн		234	270,475,472.20	100.0%	73,719	100.0%



2021 оны 2 дугаар улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 270,475,472.20 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.4 хувь буюу 36,035,701.72 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт хөрөнгийн 96.9 хувийг эргэлтийн хөрөнгө, 3.1 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байгаа бол мөнгөн хөрөнгө нийт хөрөнгийн 25.7 хувийг, цэвэр зээл 67.2 хувийг тус тус эзэлж байна.

График 7: ХЗХ-дын тоо болон нийт хөрөнгийн өөрчлөлт /тэрбум төгрөгөөр/



3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар

Тайлант улиралд зах зээл дэх нийт зээлийн үлдэгдэл 186,814,868.3 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 69.1 хувь, цэвэр зээлийн үлдэгдэл 181,775,548.93 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 67.0 хувийг тус тус эзэлж байна.

Зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 2.5 хувь байна.

1 тэрбум төгрөгөөс дээш зээлийн үлдэгдэлтэй 19 ХЗХ-ны зээлийн дүн зах зээлийн нийт зээлийн 83.1 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд тайлант улиралд 5 ХЗХ зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй байна.

Хүснэгт 11: ХЗХ-дын зээлийн хэмжээ, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Зээлийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Зээлийн дүн	Эзлэх хувь
1	1,000,000.0 дээш	19	155,192,486.46	83.1%
2	500,000.0-1,000,000.0	14	9,631,730.13	5.2%
3	100,000.0-500,000.0	67	15,600,063.80	8.3%
4	50,000.0-100,000.0	68	4,677,781.99	2.5%
5	10,000.0-50,000.0	54	1,668,282.52	0.9%
6	10,000.0 хүртэл	7	44,523.39	0.0%
7	Зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй	5	-	-
Нийт дүн		234	186,814,868.3	100%

Хүснэгт 12: Зээлийн бүтээгдэхүүнээр /мянган төгрөгөөр/

№	ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ	Зээлийн эхний үлдэгдэл /дүн/	Тайлант хугацаанд олгосон зээл	Тайлант хугацаанд эргэн төлөгдсөн зээл	Зээлийн эцсийн үлдэгдэл	Зээлийн үлдэгдлийн нийт зээлд эзлэх хувь
1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	5,297,794.45	5,973,801.60	5,405,691.51	5,865,904.54	3.1%
2	Уул уурхай, олборлолт	1,919,896.30	852,233.07	577,341.61	2,194,787.76	1.2%
3	Боловсруулах үйлдвэрлэл	2,088,409.41	796,059.92	1,228,505.07	1,655,964.26	0.9%
4	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	316,017.02	246,030.49	263,981.34	298,066.17	0.2%
5	Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	412,482.36	440,746.00	352,924.4726	500,303.89	0.3%
6	Барилга	5,069,804.09	4,278,978.54	3,530,709.51	5,818,073.12	3.1%
7	Бөөний болон жижиглэн худалдаа	15,647,923.51	10,966,231.96	10,890,950.35	15,723,205.12	8.4%
8	Машин мотоциклийн засвар үйлчилгээ	1,228,961.27	863,693.81	662,827.02	1,429,828.06	0.8%
9	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1,045,669.51	1,114,533.51	905,238.89	1,254,964.13	0.7%
10	Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	3,592,093.17	2,221,870.96	1,614,777.83	4,199,186.30	2.2%
11	Мэдээлэл холбоо	379,399.55	920,413.29	116,309.43	1,183,503.41	0.6%
12	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	4,357,542.55	16,537,459.09	9,227,251.03	11,667,750.61	6.2%
13	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	2,320,574.55	986,310.49	592,959.80	2,713,925.23	1.5%
14	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	63,457.55	231,100.00	39188.14441	255,369.40	0.1%
15	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	324,595.65	84,650.00	97,961.56	311,284.08	0.2%
16	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	5,463.55	136,300.00	2,358.43	139,405.12	0.1%
17	Боловсрол	1,072,577.15	581,232.58	693,172.56	960,637.18	0.5%
18	Хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа	968,670.55	628,550.49	373,897.22	1,223,323.81	0.6%
19	Бусад	120,648,422.24	202,623,697.20	193,852,733.36	129,419,386.08	69.3%
	Үүнээс: Хэрэглээ, цалин, тэтгэвэр, хадгаламж барьцаалсан зээл	13,012,961.70	31,626,502.81	29,345,504.28	15,293,960.22	8.2%
НИЙТ		166,759,754.42	250,483,892.99	230,428,779.13	186,814,868.28	100.0%

2021 оны 2 дугаар улирлын байдлаар ХЗХ-д нийт 250,483,892.99 мянган төгрөгийн зээл олгож, 230,428,779.13 мянган

төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдэж 186,814,868.28 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Зээлийн үлдэгдлийг

зээлийн бүтээгдэхүүнээр нь ангилахад нийт зээлийн үлдэгдлийн 69.3 хувь буюу 129,419,386.08 мянган төгрөгийг бусад, 8.4 хувь буюу 15,723,205.12 мянган төгрөгийг бөөний болон жижиглэнгийн худалдаа, 3.1 хувь буюу 5,865,904.54 мянган төгрөгийг хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, 6.2 хувь буюу 11,667,750.61

мянган төгрөгийг санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, 3.1 хувь буюу 5,818,073.12 мянган төгрөгийн барилгын зориулалтаар тус тус авсан байна. Мөн нийт зээлийн үлдэгдлийн 8.2 хувь буюу 15,293,960.22 мянган төгрөгийг хэрэглээ, цалин, тэтгэвэр, хадгаламж барьцаалсан зээл эзэлж байна.

3.4 Зээлийн чанарын талаар


Хүснэгт 13: Зээлийн ангиллын мэдээлэл /мянган төгрөгөөр/

Зээлийн ангиллын мэдээлэл	Зээлдэгчийн мэдээлэл		Зээлийн үлдэгдэл	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Нийт	32,534	100.0%	186,814,868.28	100.0%
Хэвийн	29,829	91.7%	174,783,271.82	93.6%
Хугацаа хэтэрсэн	1,470	4.5%	5,107,849.57	2.7%
Чанаргүй	1,235	3.8%	6,923,746.89	3.7%
<i>Хэвийн бус</i>	<i>403</i>	<i>32.6%</i>	<i>2,022,289.48</i>	<i>29.2%</i>
<i>Эргэлзээтэй</i>	<i>253</i>	<i>20.5%</i>	<i>1,371,800.67</i>	<i>19.8%</i>
<i>Муу</i>	<i>579</i>	<i>46.9%</i>	<i>3,529,656.73</i>	<i>51.0%</i>

2021 оны 2 дугаар улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн хэмжээнд нийт зээлийн үлдэгдлийн 93.6 хувь буюу 174,783,271.82 мянган төгрөгийг хэвийн зээл, 2.7 хувь буюу 5,107,849.57 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл, 3.7 хувь буюу 6,923,746.897 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Тайлант хугацаанд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 12,031,596.46 мянган төгрөгийн үлдэгдэлд 41.9 хувь буюу 5,039,319.35 мянган төгрөгийн зээлийн эрсдэлийн санг байгуулсан байна.

Зээлдэгчдийн мэдээллийг зээлийн чанараар ангилахад нийт зээлдэгчийн 91.7 хувийг хэвийн, 4.5 хувийг хугацаа хэтэрсэн, 3.8 хувийг чанаргүй зээл байна. Чанаргүй зээлийн үлдэгдэлтэй 1,235 зээлдэгчийн 6,923,746.89 мянган төгрөгийн үлдэгдлийн 29.2 хувийг хэвийн бус, 19.8 хувийг эргэлзээтэй, 51 хувийг муу зээлийн үлдэгдэлтэй зээлдэгчид тус тус эзэлж байна.

График 8: Зээлийн чанар



